

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 9 сарын 30 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

ХОЙШЛОГДСОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ДАХИН ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ

Монгол улсын компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3, 69.6 дах заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.3 дах заалт болон Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот, 2021 оны 45 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 10:00 цагт компанийн ажлын байр /Баянгол дүүргийн 2-р хороо Эрхи төвийн 402 тоот/-д хуралдуулсугай.
- ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:
 - Компанийг нэгтгэх тухай
 - Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай
 - Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай
 - Компанийн шинэчилсэн дүрэм батлах тухай
 - Бусад;
- Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 9 дүгээр сарын 5-ны өдрөөр тогтоосугай.
- Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахтай холбогдуулан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт №1, “Хурлын дэг”-ийг Хавсралт №2, хувьцаа эзэмшигчдээс авах “Саналын хуудас”-ыг Хавсралт №3, “Хурлын зар”-ыг Хавсралт №4-өөр тус тус баталсугай.
- Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдахтай холбогдуулан доорх бичиг баримттай 2024 оны 10 дугаар сарын 4-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн 17:00 цаг хүртэл компанийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурдсугай. Үүнд:
 - Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол болон тус тогтоолд холбогдох хавсралтуудын хуулбарууд,
 - Нэгтгэх төсөл
 - Хувьцаа эзэмшигчдийн эрх хэрэгжүүлэх журамууд
 - Дүрмийн төсөл
- Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт 2024 оны 10 дугаар сарын 3-ний дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэх, Хавсралт №4-ийн дагуу хурлын зарыг 2024 оны 10 дугаар сарын 11-ний дотор өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, Монголын Хөрөнгийн

- бирж ТӨХК-д цахим хуудсаар тус тус дамжуулан нийтэд мэдээлэх, 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор брокер дилерийн компанид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бадамцэцэгт даалгасугай.
7. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2024 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.
 8. Компанийн ээлжит бус хурлыг удирдан зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн дарга Ч.Чинзориг, комиссын гишүүнээр Ц.Сарангуа, Ж.Батбилэг, хурлын нарийн бичгийн даргаар Б.Бадамцэцэг нарыг тус тус томилсугай.
 9. Хурлын тооллогын комиссын даргаар М.Уянга, тооллогын комиссын гишүүнээр В.Шинэбаяр, Т.Батчимэг нарыг тус тус томилсугай.
 10. Хурлын бэлтгэлийг хууль, журмын дагуу сайтар зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
2024 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн
20 тоот тогтоолын Хавсралт №1



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХОЙШЛОГДСОН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК
Хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо Эрхи төв 402 тоот
Хурал хуралдах өдөр, цаг:	2024 оны 10 сарын 19 өдөр 10:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Компанийн ажлын байр /Баянгол дүүрэг, 2-р хороо Эрхи төвийн 402 тоот/
Хурлын төрөл:	Ээлжит бус
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2024 оны 9 сарын 30 өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2024 оны 10 сарын 4 өдөр
Бүртгэлийн өдөр:	2024 оны 9 сарын 5 өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2024 оны 10 сарын 9 өдөр /Цахимаар/
Хүргүүлсэн огноо:	2024 оны 10 сарын 2 өдөр
Саналын хуудас хүлээн авах сүүлийн өдөр	2024 оны 10 сарын 18 өдөр 17 цаг хүртэл
Хурлын даргын нэр:	Ч.Чинзориг
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	М.Уянга, тооллогын комиссын гишүүнээр В.Шинэбаяр, Т.Батчимэг
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт бичгийн хуудасны тоо:	ширхэг ...
	хуудас ...

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... /Ч.ЧИНЗОРИГ/

2024 оны 9 сарын 30 өдөр

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн
20 тоот тогтоолын Хавсралт №3



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС №1

Компанийн оноосон нэр: ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК
Байршил: Компанийн ажлын байр /Баянгол дүүрэг, 2-р хороо Эрхи төвийн 402 тоот/
Хурал хуралдах огноо: 2024 оны 10 сарын 19-ний өдөр 10:00 цагт

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:				
Итгэмжлэлийн дагуу төлөөлж байгаа төлөөлөгч этгээдийн тухай тайлбар:				
Регистрийн дугаар:				
Санал өгөх хувьцааны тоо:				
Утасны дугаар:				
Цахим хаяг:				
Хэлэлцэх асуудал		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийг нэгтгэх тухай			
2	Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай			
3	Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай			
4	Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах;			
5	Бусад			

Заавар: Та өөрийн саналыг (+) тэмдгээр бичнэ.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг : /
Тооллогын комисс бөглөх хэсэг:

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм Үгүй
Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн
20 тоот тогтоолын Хавсралт №2



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ

1	Бүртгэлийн үйл ажиллагаа	10 минут	Тооллогын комисс
2	Хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах	5 минут	Хурлын дарга
3	Компанийг нэгтгэх тухай танилцуулах;	15 минут	Хурлын дарга
4	Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай	5 минут	Хурлын дарга
5	Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай	5 минут	Хурлын дарга
6	Компанийн дүрмийн өөрчлөлтийг танилцуулах;		Хурлын дарга
7	Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт	5 минут	Хурлын дарга,
8	Саналын хуудсаар санал авах	10 минут	Тооллогын комисс
9	Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх	10 минут	Тооллогын комисс
10	Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тогтоолыг батлуулах	10 минут	Хурлын дарга

Хурлын үргэлжлэх хугацаа

1 цаг 15 мин

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
2024 оны 9-дүгээр сарын 30-ны өдрийн
20 тоот тогтоолын Хавсралт №4



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР

Хурлын төрөл:	Ээлжит бус
Хурал хуралдах өдөр, цаг:	2024 оны 10 сарын 19 өдөр 10:00 цагт
Хурал хуралдах газар	Компанийн ажлын байр /Баянгол дүүрэг, 2-р хороо Эрхи төв 402 тоот/
Бүртгэлийн өдөр:	2024 оны 9 сарын 5 өдөр
Хэлэлцэх асуудал:	1. Компанийг нэгтгэх тухай 2. Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай 3. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай 4. Компанийн шинэчилсэн дүрэм батлах тухай 5. Бусад;
Баримт бичигтэй танилцах:	2024 оны 10 дугаар сарын 4-ний өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн 17:00 цаг хүртэл Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 хороо, Эрхи төв 402 тоот
Холбоо барих:	info@tandem.mn tandeminvest.nbf@gmail.com 7015-1510, 89777015

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЧИНЗОРИГ

**ТАНДЭМ ИНВЭСТ БЭСБ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Огноо: 2024 оны 9 сарын 30-ны өдөр
Цаг: 10:00
Хэлбэр: Цахим

1. Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг дахин хуралдах өдрийг товлох тухай.

Гишүүд:

Ч.Чинзориг	П.Чинзориг
Ц.Билэг-Өрнөх	Ч.Тэмүдэр
Ч.Лодойравсал	А.Даваазориг
Б.Энх-Амгалан	Ч.Бадмаараг
Л.Очирмаа	

Хурлын ирц: 100%

Компанийн ТУЗ-ийн дарга Ч.Чинзориг хурлыг нээж, хурлын ирц болон хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Хэлэлцэх асуудал 1. Хойшлогдсон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг дахин хуралдах өдрийг товлох тухай.

Хурлын дарга Ч.Чинзориг: Өглөөний мэнд гишүүдээ.

2024 оны 9-р сарын 28-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц бүрдээгүйгээс хурал хүчин төгөлдөр бус болж хурлыг дахин хуралдуулах шаардалгатай боллоо. Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуульд заасны дагуу ажлын 20 өдрийн дотор дахин хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын долоогоос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ гэж заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 10-р сарын 19-ний өдөр хуралдуулах саналд та бүхэн саналаа өгнө үү

№	Хуралд оролцсон гишүүд	Санал		
		Дэмжсэн	Дэмжээгүй	Түдгэлзсэн
1	Ц.Билэг-Өрнөх	*		
2	Ч.Тэмүдэр	*		
3	П.Чинзориг	*		
4	Б.Энх-Амгалан	*		
5	Ч.Лодойравсал	*		
6	Ч.Чинзориг	*		
7	Л.Очирмаа	*		
8	А.Даваазориг	*		
9	Ч.Бадмаараг	*		

Санал хураалт: 100% дэмжсэн.

Хурал 10:35 цагт дуусав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Хурлын дарга:



Б.Бадамцэцэг

/Б.Бадамцэцэг/

Ч.Чинзориг

/Ч.Чинзориг/